

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА****2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр, Мягмар гараг****Хуралдааны тэмдэглэлийн агуулга****Хуралдааны товч тэмдэглэл:** 1-4**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 4-21

-
- | | |
|--|------|
| 1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/ | 5-7 |
| 2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай/ | 7-8 |
| 3.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудал | 8-21 |

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
12 дугаар сарын 16-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 27 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 58 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Цогтбаатар, О.Алтангэрэл, Б.Баярбаатар, Да.Цогтбаатар;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Х.Баттулга, Б.Дэлгэрсайхан, М.Нарантуяа-Нара, Г.Дамдинням;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Мөнхбаатар, Б.Тулга, Х.Тэмүүжин.

Нэг.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Я.Жавхлан, мөн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Хэрэг бүртгэх албаны дарга Б.Оюутболд, Мөрдөн байцаах албаны дэд дарга Б.Батдэлгэр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Улсын Их Хурлын даргын зөвлөх Б.Оюу-Эрдэнэ нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Эрүүгийн хэрэг хянан

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

У.Отгонбаяр: Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Улсын Их Хурлын даргын зөвлөх Б.Оюу-Эрдэнэ нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр тогтоолын төслийг тараасан талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

У.Отгонбаяр: “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Гурав.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Э.Золбоо, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд нэр дэвшигч М.Чинбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Улсын Их Хурлын даргын зөвлөх Б.Оюу-Эрдэнэ нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчид нэр дэвшигчийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Э.Золбоо танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Ц.Сандаг-Очир, С.Эрдэнэболд, О.Номинчимэг, Х.Баасанжаргал, Д.Ганбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд нэр дэвшигч М.Чинбат хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд үг хэлэв.

У.Отгонбаяр: Максимын Чинбатыг Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчоор томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 05 минут үргэлжилж, 27 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 55.5 хувийн ирцтэйгээр 15 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр,

Мягмар гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”

танхим

13 цаг 58 минут.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

У.Отгонбаяр: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Норовын Алтанхуяг ирсэн байна. Хүрэлбаатарын Баасанжаргал ирсэн байна. Энхбаярын Батшугар ирсэн байна. Жудгийн Баярмаа ирсэн байна. Дашдондогийн Ганбат ирсэн байна. Одсүрэнгийн Номинчимэг ирсэн байна. Салдангийн Одонтуяа ирсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж ирсэн байна. Даваахүүгийн Пүрэвдаваа ирсэн байна. Ухнаагийн Отгонбаяр ирсэн байна. Пүрэвжавын Сайнзориг ирсэн байна. Цэндийн Сандаг-Очир ирсэн байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд ирсэн байна. Сүхболдын Эрдэнэболд гэсэн гишүүд хүрэлцэн ирснээр ирц бүрдэж байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн Байнгын хорооны хурлаар 3 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан ажлын хэсгийн дүгнэлт, анхны хэлэлцүүлэг.

2 дугаарт, Байнгын хорооны тогтоолын төсөл. “Тогтоол хүчингүй болгосонд тооцох тухай”.

3 дугаарт, Бусад асуудлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудал. 2025 оны 12 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн байна. Эдгээр 3 асуудлыг хэлэлцэхээр байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж санал байна уу?

Санал байхгүй. Хэлэлцэх асуудлыг баталъя.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Эхний асуудал 1 дүгээр асуудал. Хэлэлцэх асуудалдаа оръё.

1 дүгээр асуудал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн ирц цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан төсөл, анхны хэлэлцүүлэг/

Хуулийн төслийг боловсруулсан талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг танилцуулна.

Н.Алтанхуяг: Эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын халдашгүй чөлөөтэй байх, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч баривчлах, хорих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж болохгүй. 14 дэх заалтад шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй. Гэм буруутайн хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасныг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 6 сарын 13-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны 9 сарын 23, 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзэж Монгол Улсын Их Хурлын “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийн тухай 92 дугаар” тогтоолыг баталсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5 дахь хэсэгт энэ хуулийн 84.3-д заасан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж, нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасны дагуу Хууль зүйн байнгын хороо 2025 оны 9 сарын 29-ний өдрийн 13 дугаар тогтоолоороо Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд холбогдох хэсэгт зохих өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Их Хурлын гишүүн Алтанхуяг, гишүүдэд Монгол Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл, Отгонбаяр, Сайнзориг, Тэмүүжин, Уянгахишиг, Энхбаяр нар ажиллалаа.

Ажлын хэсэг хуулийн төслийн талаар холбогдох байгууллагуудаас санал авч 5 удаа хуралдаж, хуулийн төслийг дараах байдлаар боловсруулав. Тодруулбал, 1 дүгээрт шүүгдэгчийг цагдан хорих, таслан сэргийлэх үндэслэлийг тодорхой болгож, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан яллагдагчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлийг шүүгдэгчид адил хамаарахаар, мөн хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

үйлдсэн гэм буруутайд тооцогдсон бол шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч болох бөгөөд ингэхдээ прокурор оролцогчийн саналыг харгалздаг байх зохицуулалтыг тусгалаа.

2 дугаарт, Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааныг хойшлуулах, завсарлуулах, хэргийг түдгэлзүүлэх, тусгаарлах, буцаах, шүүгдэгчийг гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэх зэрэг асуудлаар шийдвэр гаргах үед таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой прокурор оролцогчийн гаргасан санал, хүсэлтийг хэлэлцэж шийдвэрлэдэг байх зохицуулалтыг тусгалаа.

3.Шүүх яллагдагч, шүүгдэгчид урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлсэн, өөрчилсөн, хүчингүй болгосон шийдвэр гаргасан бол уг шийдвэртээ тэдгээрийн үндэслэлийг заавал тусгаж байх зохицуулалтыг тусгалаа.

4.Дээр дурдсан асуудлыг хуулийн төсөлд тусгаж боловсруулсантай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтэд тусгагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гэж заасныг хүчингүй болсонд тооцох зохицуулалтыг тусгалаа.

5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болохоор тусгалаа.

6.Хуулийн төслийг бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулж төслийн зүйл хоорондын нийцлийг хангасан болно. Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

У.Отгонбаяр: Алтанхуяг гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуулттай холбогдуулан хуралдаанд хүрэлцэн ирсэн албан тушаалтнуудыг танилцуулъя.

Н.Чинбат Улсын Ерөнхий прокурорын орлогч, Хэрэг бүртгэх, мөрдөн шалгах үйл ажиллагаанд хяналт биш, энэ Улсын Ерөнхий прокурорын орлогч. Дараагийн хүн Я.Жавхлан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Б.Батзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Б.Оюутболд Цагдаагийн ерөнхий газрын Хэрэг бүртгэх албаны дарга, цагдаагийн хурандаа, Б.Батдэлгэр Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга, Лхагвацэнд Хууль зүй, дотоод хэргийн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Эрүүгийн хэргийн хянаж хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу?

Асуулт, саналтай гишүүн алга.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-д заасныг баримтлан хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна.

Горимын саналаар санал хураая. Гишүүд санал хураалтад бэлтгэнэ. Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Саяын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Горимын санал 11 гишүүн дэмжсэнээр дэмжигдлээ. 73.3 хувь.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг танилцуулна. Дараагийн асуудалдаа орёе.

14.10 цаг

Хоёр дахь асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл “Тогтоолын төсөл хүчингүй болсонд тооцох тухай”.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль тогтоомжийн төслүүдийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Их

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хурлын даргын захирамжаар байгуулахаар болсонтой холбогдуулан боловсруулсан “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу?

Байхгүй байна. Гишүүд асуулт асууж, үг хэлэх гишүүн байхгүй. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураая. Санал хураалт.

Тогтоолын төсөл дэмжигдлээ. 11 гишүүн дэмжиж, 73.3 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг эцэслэн хэлэлцэн шийдвэрлэлээ.

14.12 цаг

3 дугаар асуудал. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх асуудал.

3 дахь асуудал. Улсын Ерөнхий прокурорын олгогчийн албан тушаалд нэр дэвшигч Максимын Чинбатын танилцуулгыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Энхтүвшиний Золбоо танилцуулна. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Э.Золбоо: Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 17 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу Максимын Чинбатыг Улсын Ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилох саналыг зөвшилцөхөөр танилцуулж байна.

Адуучин сүрэг овогтой Максимын Чинбат 1973 онд Сүхбаатар аймагт төрсөн. 52 настай. Ам бүл 6, эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг. 1981-91 онд Сүхбаатар аймагт Ерөнхий боловсролын дунд сургууль, 91-95 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн. Хууль зүйн ухааны магистрын зэрэгтэй. Төрийн хууль, цаазын шадар зөвлөх зэрэг дэвтэй.

М.Чинбат 1995 оноос Сүхбаатар аймгийн Прокурорын газарт хяналтын прокурор, Аймгийн прокурорын орлогч, Аймгийн прокурор, 2007 оноос Багануур дүүргийн Прокурорын газарт туслах прокурор, Дүүргийн прокурорын орлогч, 2014 оноос Дүүргийн 1 дүгээр прокурорын газарт Тамгын хэлтсийн дарга, 2015 оноос Баянгол дүүргийн Прокурорын газарт хяналтын прокурор, Тамгын хэлтсийн дарга, 2017 оноос Чингэлтэй дүүргийн Прокурорын газарт ахлах прокурор, 2019 оны 2 дугаар сард Улсын Ерөнхий прокурорт Хяналтын прокурор, мөн оны 4 дүгээр

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

сараас Улсын Ерөнхий прокурорын орлогчоор тус тус томилогдон прокурорын байгууллагад прокуророор 30 дахь жилдээ ажиллаж байна.

Иймд Максимын Чинбатыг Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчоор томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэлэлцэн шийдвэрлэхийг хүсье.

У.Отгонбаяр: Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн нэр дэвшигчийн танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгон нэр дэвшигчээс асууж асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу?

Ганбат, Сандаг-Очир. Сандаг-Очир гишүүнээр тасалъя. Таных уу? Сайнзориг гишүүн, Эрдэнэболд гишүүн хоёрынх орсонгүй. 6 гишүүн. Ганбат гишүүнээр тасалъя. Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлье.

П.Сайнзориг: Чинбат орлогчийг бас сунгаж ажиллуулахаар ийм санал оруулж ирж байгаа юм байна. Тэгээд би зүгээр танаас би Чинбат прокурортой бас хууль боловсруулж бас ажиллаж байсны хувьд ерөнхийд нь гадарлана. Тэгэхдээ одоо нэгэнт прокурорын бас удирдлага дээр сунгаж, удирдлагуудын бүрэлдэхүүнд сунгаж ажиллах гэж байгаа учраас та яг бас хувь хүн талаасаа, дээрээс нь мэргэжлийн талаасаа ер нь энэ прокурорын удирдлагад ажиллаж байгаагийн хувьд бас яг энэ асуултад хариулж өгөөч гэж хүсэж байгаа юм.

Ер нь прокурорын ёс зүйн асуудлыг шийдвэрлэж байгаа өнөөгийн тогтолцоо хэр зөв байна вэ? Зөв үү, эсвэл та бас өөрчлөх шаардлага байна гэж үзэж байгаа юу? Өнөөдөр яг хуульчдын дундаас ганцхан өөрөө өөрийнхөө ёс зүйн асуудлыг шийдвэрлэдэг бүрэлдэхүүн нь тэр чигтээ прокурорууд өөрсдөө байдаг нь ганцхан энэ байгууллага л үлдчихээд байна. Шүүгч нарыг бүүр Улсын Их Хурлаас томилогдож байгаа Сахилгын хороо шийдвэрлэж байна. Өмгөөлөгч нар нь, хуульч нар нь тусдаа бас сахилгын хороотой. Эдгээр нь тал талын бүрэлдэхүүнтэй. Багш, судлаач, олон нийтийн төлөөлөл. Прокурорт ийм зүйл байхгүй. Тэгэхээр өнөөдрийн энэ яг ёс зүйн асуудлын энэ дээр шийдвэрлэж байгаа энэ зүйлүүд дээр таны тогтолцоо, байгаа байдал ер нь хэр зөв гэж бодож байна? Энэ дээр 1 дүгээрт хариулж өгөөч.

2 дугаарт, Прокурорын нөгөө цахимжилтыг та мэдэж байгаа байх. Энэ цахимжилтыг шийдвэрлэхэд ер нь цаашдаа юуг хийх зайлшгүй шаардлага байна? Ялангуяа зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа дээр 2 сая зөрчлийг хэдүүлээ нэг цахимаар шийдье гээд явж байсан. Сая улсын төсөв дээр 4.7 тэрбум төгрөгийн хэрэгтэй гэж байсан боловч дэмжигдээгүй. Тэгэхдээ сүүлд нэг задаргаатай төсөв дээр нэг аравны хэд ч билүү л орж ирж байх шиг байна лээ. Энэ хүрэлцэж байна уу? Уг нь ингээд прокурорууд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа дээр хэт оролцох биш гомдлоор бас энэ үйл ажиллагаан дээр хяналт тавья. Энийг шийдвэрлэх гол гарц гарц нь цахимжилт юм байна. Прокурорын үүд хаалгыг улсын байцаагч нар манаж суугаад зөрчлийн хэргийн дугаар авах гээд ингээд энэ нөхцөл байдлуудыг больё оо гээд ингээд олон жил ярьж байгаа. Энэ яах вэ зүгээр нэг л өнцөг нь. Тэгэхээр энэ цахимжилтын асуудал дээр та ер нь прокурорын байгууллага талаас юу гэж харж байна? Цаашдаа юуг хийх зайлшгүй шаардлага байна гэж бас харж байгаа. Энийг бас бас Хууль зүйн байнгын хороонд бас нэг дуулгаж хэлээч гэж хүсэж байна.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ер нь тэгээд гэмт хэрэг, зөрчлийн ерөнхий энэ нөхцөл байдлыг манай прокурорын байгууллага Улсын Их Хурлын өмнө бас оруулж ирж байгаа. Тэгэхээр би зүгээр цааш цаашдаа яг энийг бас үнэн, бодит бас тодорхой яг хариу арга хэмжээг бодитой авахын тулд энэ чиглэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт бас судалгаатай хандах чиглэлд бас прокурорууд цаашдаа юуг анхаарах вэ?

У.Отгонбаяр: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон. Нэр дэвшигч Максимын Чинбат.

М.Чинбат: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Сайнзориг гишүүний асуултад. Тэгээд яг миний Ерөнхий прокурорын өмнө хариуцан ажилладаг чиглэл бол 2 орлогчтой байдаг. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих ажил, шүүх, төрийг төлөөлөх ажлыг яг дагнан хариуцан ажилладаг, прокурорын дэргэдэх мэргэжлийн зөвлөлийг бас хариуцаж ажилладаг. Таны асуусан асуултад би яг бүрэн дүүрэн хариулт өгч чадахгүй байх гэж бодож байна. Яагаад гэвэл өөрөө хариуцаж байгаагүй. Тэгэхдээ Ерөнхий прокурорын орлогчоор 6 жил ажиллаж байсныхаа хувьд би бас та бүхэнд хариулт өгье гэж бодож байна.

Прокурорын ёс зүйн асуудлыг Прокурорын ёс зүйн зөвлөл авч хэлэлцдэг. Зөвлөлийн ажиллах дүрэм, журмыг холбогдох институт баталж ингэж явж байгаа. Ер нь аль болох прокурорын ёс зүйн асуудлыг нээлттэй, ил тод авч хэлэлцэх. Авч хэлэлцэж байгаа тэр субъект нь өөрөө бас олон талын субьектийг хамруулсан байх энэ шаардлагыг олон улсын байгууллагууд зөвлөж өгдөг. Ялангуяа Зүүн өмнөд Ази, Зүүн Европ эдийн засгийн хөгжлийг дэмжих Станбулын төлөвлөгөө гэж бас байгаа. Тэр дээр бас бас прокурорын энэ томилгоо, ёс зүйн асуудалтай холбоотой хэд хэдэн зөвлөмжийг бидэнд өгсөн. Зөвлөмжийг амьдрал дээр хэрэгжүүлэхийн тулд бид одоо байгаа хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг бас зөв талаас нь шийдэх ийм бодлого, чиглэлтэй ажиллаж байгаа гэж хариулъя.

2 дугаарт, цахимжилтын хувьд манайх Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг Их Хурлын тогтоолын дагуу Хууль зүйн яамны захиалгаар хийж 26 оны 1 сарын 1-нээс бараг прокурорын үйл ажиллагаа, зөрчлийн хэрэг бүртгэх эрх бүхий байгууллага гэдэг үйл ажиллагаанд бүрэн хэрэгжүүлэхээр ингэж бэлтгэл ажлыг хангуулж байгаа.

Тэгэхээр зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа ингээд цахимжилтаар тодорхой хэмжээнд бас бүртгэлийнхээ хувьд ч гэсэн прокуророос тавих хяналт ч гэсэн цахимаар явагдах ийм боломж нөхцөл бүрдэж байгаа. Эрүүгийн хэргийн хувьд ч гэсэн бид бас Эрүүгийн хавтаст хэргийг цахимжуулах тал дээр бас гаднын энэ байгууллагуудтай хамтарч бас ажиллаж байгаа. Хууль тогтоомжийн хувьд ч гэсэн цахимаар явуулж болно оо гэдэг эрх зүйн орчин бас нэг талаасаа хуульчлагдаад гараад ирсэн. Энийг цааш цаашдаа бид бас эрүүгийн хэргийг цахимжуулах энэ ажил дээр бас тодорхой бодлого, чиглэл, ажил, арга хэмжээ авч ажиллаж ажиллаж байгаа.

У.Отгонбаяр: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Би ингээд Чинбат прокурорыг бас сунгаж бүрэн эрхийг нь үргэлжлүүлэх гэж байгаа дэмжиж байна гэдгээ хэлье. 2 дугаарт саяын 2 асуултын

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

цаана би бас Прокурорын байгууллагын шинэчлэл зайлшгүй бас яригдах ёстой шүү. 17 онд Прокурорын байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг миний бие өөрөө яг боловсруулж байсан. Тэн дээр яах вэ зүгээр миний хувь өнцөг талаасаа тухайн үедээ цагдаагийн байгууллагаас прокурорын удирдлагуудад маш их хэмжээний хүмүүс томилогдож ирээд байсныг хааж, прокурор дундаасаа удирдлагууд томилогддог энэ систем рүү орсон юм.

Тэгэхдээ аливаа гаднаас урсгалгүй буюу энэ цус сэлгэлт гэх үү тодорхой тэр жоохон гаднаас боловсон хүчний сэлгэлт энэ тэр хийх энэ асуудал бас их ужгираад ирэхээрээ яг нэг замаграад гэдэг юм уу нуур нэг замаграад л нэг ширгэдэг шүү дээ энэ юм руу орчих вий дээ гэж би бас бодох юм. Тийм учраас цаашдаа энэ прокурорын байгууллагын тогтолцоо, удирдлагуудад тавигдах шаардлага энэ тэрийг бас нэг сайжруулах чиглэлд.../минут дуусав./

У.Отгонбаяр: Сандаг-Очир гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ц.Сандаг-Очир: Бүрэн эрхийн хугацаа дуусаад үргэлжлүүлээд сунгаж ажиллуулахаар ингэж орж ирж байгаа юм байна. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр дэмжигдвэл Улсын Их Хурлын чуулганаар ингээд ороод санал хураалтаар шийдэгдэнэ. Өнгөрсөн хугацаанд 6 жилийн хугацаанд ажиллахад прокурор дээр өөрөө бас өөрийнхөө ажлыг ер нь юу гэж дүгнэж байна? Ямар эерэг үр дүн гарав, ямар ололт, амжилт гарав? Ямар хуулийн, эрх зүйн, хууль зүйн шинж шинэчлэл хийв? Өнөөдрийн энэ мөрдөгдөж байгаа Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудын өөрчлөлтүүд бид бүхэн бас өнгөрсөн хугацаанд багагүй хуулиудын өөрчлөлтүүдийг хийсэн. Ер нь цаашид бас засаж залруулах ёстой хууль хоорондын зөрчилтэй хуулиуд юу байна гэж үзэж байна? Цаашдаа ер нь прокурорын байгууллага Улсын Их Хурал тэр дундаа Хууль зүйн байнгын хороотойгоо хамтарч бас энэ хуулийн, эрх зүйн шинэчлэлийг хийхэд ямар асуудлууд байна гэж хувьдаа үзэж байна вэ гэдгийг 1-д асууя.

2-т, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх ажил дээр үеийн Засгийн газар бас анхаарал хандуулж ажиллаж байгаа. Мөрдөн байцаагч нарын боосон, хянасан хэргүүд Прокурор дээр очоод замхардаг гэдэг асуудлууд байдаг. Прокуророос анхан шат руу буцдаг, хэрэгсэхгүй болдог оо эд нар гэдэг асуудлууд байна. Өнөөдөр ийм өнгөрсөн хугацаанд ер нь өөрийн чинь ажилласан хугацаанд ер нь авлига, албан тушаалын хэчнээн хэрэг шийдэгдэв? Төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой? Одоо яг үлдэгдэлтэй он дуусах гэж байна 25 он одоогийн байдлаар ер нь албан тушаалтнуудын авлигын гэмт хэргийн явц гэдэг юм уу, хэргийн прокурор дээр байгаа үлдэгдэл хэрэг хэчнээн хэрэг хянагдаж шалгагдаж байна? Ер нь прокурор дээр хэчнээн хэрэг хянагдаж ирсэн байгаа вэ? Энэ дээр та бүхэн яаж анхаарал хандуулж ажиллаж байна вэ? Нийгэм энийг маш их анхаарч, хүлээж, хүлээлттэй байгаа. Ерөнхий сайд маань бас авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тууштай тэмцэнэ гэдгээ мэдэгдэж байгаа. Тийм учраас прокурорын байгууллага энэ Засгийн газар, Улсын Их Хурлын бодлоготой нийцэж, яаж ажиллаж, анхаарал хандуулж, ач холбогдол өгч ажиллаж байна вэ? Өнгөрсөн хугацаанд хэчнээн гэмт хэргийг илрүүлж, хэчнээн гэмт хэрэгт хяналт тавьж ингэж ажилласан байна вэ гэдэг талаар нэг товч мэдээлэл өгөөч та?

У.Отгонбаяр: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Нэр дэвшигч Максимын Чинбат 3 дугаар микрофон.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

М.Чинбат: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль гээд энэ бидний хэрэгжүүлдэг гол гол хуулиуд 2017 онд бас концепцын хувьд, үзэл баримтлалынхаа хувьд нэлээд өөрчлөгдөж ингэж шинэчлэн ингэж гарч ирсэн. 2019 оноос ер нь шүүх, хуулийн байгууллагууд хуулийг хэрэгжүүлэх тал дээр юун дээр нь энэ шинэ хуулиуд хэрэгжиж байна. Алин дээр нь алдаа дутагдал байна, хийдэл байна, давхардал байна гэдэг энэ асуудал хууль хэрэгжүүлэх, хууль хэрэглэх явцад бас нэлээдгүй гарч ирсэн. Энэ хүрээндээ прокурорын байгууллагыг төлөөлж миний бие энэ Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүйн яамны энд байгуулагдсан ажлын хэсгүүдэд бас нэлээд цөөнгүй ажиллаж ирсэн.

Энэ хүрээндээ ч гэсэн бид энэ хуулийг хэрэгжүүлэхэд гарч байгаа энэ бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд бас өөрсдийн байгууллагын зүгээс гаргаж байгаа, баримталж байгаа энэ бодлого чиглэл, яг хууль практик дээр юу нийцэж байна вэ гэдэг талаас нэлээн санаачилгатай ажил гаргаж, санал гаргаж ингэж шийдвэрлүүлж ирсэн. 10 гаруй удаагийн ажлын хэсэгт ажиллаж, ер нь хүний эрхийг хангах, хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээхийн чиглэлээр яг эдгээр энэ Эрүүгийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад бас нэлээн сайн дэвшилтэт заалт, өөрчлөлтүүд орж ирсэн. Энэ нь ч гэсэн одоо хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааг бас нийгэмд зөв талаас нь харуулах, зөв хүний эрхэд чиглэсэн ийм өөрчлөлтүүд орж ирсэн гэдэг нь тоон статистик мэдээллээс харагдаж байгаа.

Ялангуяа хүнийг баривчлах, цагдан хорих явдал байна. Энэ дээр хуулийнх нь үндэслэлийг нь сайтар тусгуулж, хэрэглэж байгаа мөрдөгч, прокурорууд нь, шүүгч нар нь үндэслэлээ шийдвэртээ сайн тусгадаг энэ байдал дээр гарч ирж хүний эрхэнд халдах явдал бас буурсан 6 жилийн хугацаанд.

Авлигатай тэмцэх асуудлын хүрээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Авлигын эсрэг конвенцынхоо хүрээнд энэ мөрдөн шалгах байгууллагад хамтарч ажилласан. Энэ үр дүнгээрээ ч гэсэн 2019 онд шалгаж байсан хэрэг, түүний шийдвэрлэлт, 24 оны жилийн эцэстэй харьцуулахад нэлээд үзүүлэлтүүд гарч ирдэг. Тухайлбал, 2019 онд бид 970 хэрэгт хэрэг бүртгэл мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байсан бол 24 онд 1742 хэрэг шалгуулсан байна. Энэ нь 5 жилийн өмнөхөөсөө 80 хувиар өссөн гэмт хэргийн хувьд. Шийдвэрлэлтийн хувьд бид 2019 онд 89 хэргийг л авлигын гэмт хэргийг шүүхэд шилжүүлж байсан 19 онд. 24 онд 306 болж 2.4 дахин ийм өссөн үзүүлэлттэй байдаг. Прокуророос, мөрдөн шалгах байгууллагаас саналтай ирүүлсэн хэргийг хянаад шүүхэд шилжүүлэх, эс үгүй бол.../минут дуусав./

У.Отгонбаяр: Гүйцээж хариулъя 3 дугаар микрофон.

М.Чинбат: Авлигын хэргийг прокурор хянаад хуульд заасан үндэслэлүүдээр шийдвэр гаргадаг. Энд шүүхэд шилжүүлэх, хэрэгсэхгүй болгох, нэмэлт ажиллагаа хийлгэх. Тэгэхээр 2019 онд бид 29 хэргийг авлигын гэмт хэргээр зүйлчилсэн хэргийг 29 хэргийг хэрэгсэхгүй болгож байсан юм байна. Тухайн үедээ энэ үндэслэл хуульд заасан үндэслэл, журмынхаа дагуу хийгдэж байсан байх хэрэг нэг бүр дээр. Ер нь хэргийн үндэслэл бас өөр байдаг. Ингээд бид 24 онд 7 хэргийг хэрэгсэхгүй болгож байсан. Шүүхэд шилжүүлсэн хэргийг сая би тоо хэллээ.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгэхээр яг прокурорын шатад хэрэг хэрэгсэхгүй болгодог, шийдвэрлэдэггүй гэдэг энэ шүүмжлэл бас нэг талаасаа энэ тоон үзүүлэлттэй уялдах байх.

2 дугаарт, мөрдөн шалгах ажиллагааны чанар, үр дүнгээс хамаарч бид шийдвэрээ гаргадаг. Үнэхээр мөрдөн шалгах ажиллагаа чанартай, үр дүнтэй ингэж явагдах бол бид яг хуульд заасан үндэс бүхий шийдвэрээ гаргаад ингээд асуудлыг шийдвэрлэх бүрэн боломжтой гэж дүгнэж байна.

У.Отгонбаяр: Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлье.

С.Эрдэнэболд: Би 4 асуулт асууя. 1 дүгээрт 30 жил прокурорын байгууллагад ажиллаж байгаа 95 оноос хойш тасралтгүй. Бие даасан энэ мөрдөх, мөрдөн шалгах албаны асуудлаар ер нь яригдаад байдаг энэ дээр таны байр суурь ер нь ямар байдаг вэ?

2 дугаарт нь болохоор энэ хүний эрхийн төлөв байдлыг сайжруулахад энэ хууль, хүчний байгууллага, тэр тусмаа прокурорын оролцоог та хэрхэн үздэг вэ?

3 дугаарт бизнес эрхлэгчдийг тодорхой хэмжээнд эрх ашгийг нь хаадаг, боомилдог, дарамталдаг, бизнес эрхлэгчдэд төрийн дарамт үзүүлдэг нэг том байгууллага нь энэ хууль хүчний байгууллага гэсэн шүүмжлэл иргэдийн дунд маш их байдаг. Тэр тусмаа улс төрийн сонгуулийн үеэр ямар нэгэн зохион байгуулалттай гэмт хэрэг гаргаж, Баярмаа гишүүн та түр байж байгаач, гаргаж улмаар улс төрд тодорхой ялалт байгуулах зорилгоор явцуу ашиг сонирхлын хүрээнд хэн нэгэн хүнийг буруутгаад, эс үгүй бол хэсэг бүлэг хүнийг буруутгаад янз бүрийн хэвлэл мэдээллийн Пи Ар хийгээд түүнийгээ цагдаагийн байгууллага болон прокуроруудаар мэдээлэл хийлгүүлдэг. Сонгууль дуусаад алга болчихдог. Тэгээд энэ дээр ер нь та ер нь ямар байр суурьтай байдаг вэ? Энэ дээр их харамсдаг байхгүй юу. Би прокуроруудын гэр бүлд өссөн, прокурорын зовлонг хамгийн сайн мэддэг хүн. Гэхдээ энэ прокуроруудыг заримдаа нохойд барьдаг мод шиг байгаад нь харамсдаг. Гэхдээ зарим үед бас зарим прокурорууд энэ дээр бас зоригтой тэмцэж, улс төрчдийн эсрэг зарчим хэлж чаддаг байсан үеүд байдаг.

4 дүгээр асуулт. Та өөрийн хүсэл зоригоор энэ сунгагдах, ажлаа үргэлжлүүлээд хийх дээр өөрийн хүсэл зоригоор энэ шийдвэрийг гаргаж байгаа юу? Эс үгүй бол дээд шатын прокурор ч гэдэг юм уу ер нь таныг үргэлжлүүлж ажилла гэдэг саналыг хүлээж авч байгаа юу? Энэ ялгаатай асуудалд учраас.

Прокурорын Тамгын газрын дарга хажууд нь сууж байгаа Тамгын газрын дарга гэсэн тээ? Би энэ зүгээр Ерөнхийлөгчийн дарга, хэлтсийн дарга нь байна уу? Прокурорынхон зүгээр нэр дэвшигчид хандаад биш, нэр дэвшигчид хандаад биш би нэг юм хэлчихье. Энэ 12 сарын 15-нд бид нарт ирүүлсэн бичиг ингээд кирилл болон үндэсний бичиг 2-оор ирж байна. Тэгээд 1 сарын 1-нээс бид нар нөгөө үндэсний бичгээ хэрэглээд 1 жил болох гэж байна л даа албан ёсны. Прокурорын, ерөнхий прокурорын гарын үсэгтэй Монгол бичгээр ирүүлж байгаа бичиг дээр үг, үсгийн 51 алдаа байна. Аймгийн нэр, албан тушаалын нэр, аягүй олон зүйлийг буруу бичсэн байгаа.

Тэгэхээр ингэж бас гурилдаж болмооргүй байна. Тийм учраас энэ Монгол бичгээр албан хэрэг хөтлөхдөө энэ прокурорын байгууллага гэхэд 120, 30 үгтэй албан бичгийн 40 хувь нь алдаатай байна гэдэг чинь аягүй онцгүй байна шүү дээ.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгэхээр энэ дээрээ засвар хийгээрэй гэж Прокурорын байгууллагын энэ хүний нөөц нь анхаардаг юм уу, яадаг юм, энэ яах вэ ингээд зүгээр өнгөрөөчхөж болно л доо. Гэхдээ энэ чинь төрт улсын бас нэг том бахархлыг бид нар бас.../минут дуусав./

У.Отгонбаяр: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Нэр дэвшигч Максимын Чинбат 3 дугаар микрофон.

М.Чинбат: Гишүүний асуултад хариулъя. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах бие даасан байгууллага алба байх ёстой юу гээд. Тэгэхээр энэ шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгадаг хуучин өмнө нь алба байсан. 2014 онд татан буугдсан байх 12 жил ажиллаад. Тэрнээс хойш одоо өнөөдрийн нөхцөл байдалд бид тухайн субъектээс үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах байгууллагуудад нь сөөлжүүлэх маягаар харьяалал тогтоож ингэж өгч шалгуулж байгаа. Олон улсын байгууллагаас өгч байгаа зөвлөмж үндэсний ийм тусгай ийм тогтолцоотой байгууллага байх ёстой л гэдэг ийм зөвлөмж өгдөг. Бид тодорхой саналуудыг Хууль зүйн яаманд, Засгийн газарт уламжилж байсан ийм л нөхцөл байдалтай байгаа.

Хоёрт, хүний эрхийн төлөв байдлын талаар хүний эрхийн байгууллагуудтай ер нь бид байнга л хамтарч ажиллаж, хүний эрхийн талаар прокурорууддаа сургалт хийдэг. Бид хүний эрхийн чиглэлээр хамгийн анх хуулийн байгууллагуудаасаа сургагч багш бэлдсэн субъект юм шүү дээ. Тэгэхээр хүний эрхийн энэ байгууллага, гишүүдтэйгээ бид хамтарч ер нь хүний эрхийг хангах, хамгаалах талаар нь ямар оновчтой арга барилаар ажиллах вэ, ажлын арга барил, сэтгэхүй, хандлага дээрээ ямар өөрчлөлт гаргах вэ гэдэг дээр бид хүнээ бэлдээд байгаа. Тэгсэн хэр нь бидний олон нийтээс тавьж байгаа шаардлагад бас 100 хувь хүрэхгүй ийм асуудлууд байгаа гэж хариулъя.

3 дугаарт, бизнесийн үйл ажиллагаа, улс төрийн үйл ажиллагаанаас ер нь прокурорын байгууллага хараат бусаар ангид ажиллах ийм зарчимтай, зорилготой хуульд, бид ямар нэгэн нийгмийн хүлээлт гэдэг юм уу, улс төрийн үйл ажиллагаа энд автагдаж асуудлыг шийдэхгүй байх ийм зарчимтай ажилладаг.

4 дүгээрт, энэ Улсын Ерөнхий прокурорын орлогчоор томилогдох энэ асуудал энэ манай Прокурорын тухай хууль, Ерөнхийлөгчийн тухай хууль номынхоо дагуу явагдаж байгаа. Ер нь Ерөнхий прокурор санал болгож Ерөнхийлөгчид уламжилдаг. Надад бол санал болгосон учраас би энэ ажлыг, энэ саналыг нь хүлээж авч ингэж орж ирж байна.

У.Отгонбаяр: Эрдэнэболд гишүүн тодруулъя. Би энэ Хүний эрхийн дэд хорооны даргын хувиар бас нэлээн олон шүүх хурлуудад ажиглагчаар ер нь суусан өнгөрсөн жилийн хугацаанд. Ер нь харж байхад шүү би бол яг тодорхой нөгөө зарим процессын шатдаа явж байгаа хэргүүд учраас энд ярьж болохгүй.

Гэхдээ ер нь маш их учир дутагдалтай байна лээ. Ялангуяа улс төрчидтэй холбоотой, улс төрд нөлөө бүхий алба хашиж байсан хүмүүс дээр яллах дүгнэлт үйлдэхдээ маш олон төрлийн практикт байдаггүй зүйлүүдийг эд нар эшилж байгаа зүйлүүд байсан. Тэгэхээр дахин дахин хэлээд байгаа шалтгаан нь Транспэрэнси Интернэшнлаас өгч байгаа Монголын авлигын индексийг бууруулах 3 зөвлөмжийн

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

1 нь энэ улс төр, улс төрч ба энэ хуулийг хэрэгжүүлэх байгууллагын энэ харилцаа хамаарлыг л багасга гээд байгаа. Тэгэхээр та цаашид ажил.../минут дуусав./

У.Отгонбаяр: Номинчимэг гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Номинчимэг: 3 асуулт асууя гэж бодож байна нэр дэвшигчээс. Та 6 жил Прокурорын орлогч даргаар бас ажиллалаа. 30 жил энэ прокурорын байгууллагад ажиллаж байна. Ер нь олон нийтийн дунд прокурорын байгууллагын нэр хүнд гэдэг юм уу, эсвэл болж байгаа, бүтэж байгаа юм, болохгүй байгаа, бүтэхгүй байгаа юм гээд ер нь маш нэлээн бас гүн сэтгэгдэлтэй хүмүүс их олон байдаг. Тэгээд та бол хууль тогтоомжийн шинэчлэлийн талаар бас ахиц дэвшил гарсан талаар дурдлаа. Ахиц дэвшил гараагүй уруудаж байгаа зүйл нь харин юу байна гэдэг дээр та бас өөрийнхөө байр суурийг илэрхийлээч. Цаашид та 6 жил дахиад прокурорын орлогчоор ажиллах хугацаандаа хамгийн сайн анхаарч, энэ дээр хүч хөдөлмөрөө зарж өөрчлөлт хийнэ гэсэн тооцож байгаа энэ асуудлуудыг 1 дүгээрт сонсмоор байна.

2 дугаарт, прокурорын хараат бус байдлын талаар ний нуугүй хэлэхэд улс төрийн хүрээнийхний дунд, төрийн албаныхны дунд бараг л нээлттэй шахуу л яригддаг болчихоод байгаа шүү дээ. Хэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад хэрэг дээрээ прокурор дээр дээрээс чиглэл өгсөн, тэгэх юм бол яаж ч болохгүй байна гэдэг ийм хариултаар янз бүрийн хэрэг цаашаагаа явдаг, эсвэл явахаа больдог гэдэг асуудлууд яригдаж байна. Тэгээд энэ үнэн үү? Энийг бид нар тэгвэл багасгахын тулд юу хийх ёстой вэ? Прокурорын хараат бус байдлыг хангахын тулд бид нар хууль тогтоомжийн хувьд, дотоод зохион байгуулалтын хувьд юу хийх ёстой гэж та харж байна гэдгийг хэлмээр байна.

3 дугаарт нь энэ Хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль байгаа. Та ингээд Улсын Их Хуралтай зөвшилцөж томилогдох гэж байгаа албан тушаалтан. Тэгээд ингээд харахаар Улсын Их Хурал жилд жил болгон нэг өөрсдийнхөө мэдээлэл хууль тогтоомжийн хэрэгжилтийг тайлагнадаг хэдэн албан тушаалтан, байгууллагууд байдаг. Тэрний нэг нь Улсын Ерөнхий прокурор Эрүүгийн болон Зөрчлийн хууль тогтоомжийн биелэлтийн талаар Ерөнхий прокурорын мэдээллийг жилд 1-ээс доошгүй удаа Улсын Их Хуралд ирүүлдэг. Ирүүлээд тэрийг нь Улсын Их Хурал нээлттэй цахим дээрээ тавьдаг. Тэгтэл энэ жилийнх нь 3 сард ирсэн гэж байгаа юм. Тавиагүй би л лав, би л лав энийгээ харахгүй байна. Энэ бусад юу гэдэг юм тэр төрийн алба ч байдаг юм уу, жендертэй холбоотой ч байдаг юм уу эд нар Эрүүл мэндийн даатгал, Үндэсний статистикийн хороо эд нар бүгдээрээ хэлэлцэгдээд явдаг, тайланд ордог. АТГ болон Улсын Ерөнхий прокурорын хууль тогтоомжийн биелэлтийн талаарх энэ мэдээлэл ерөөсөө хэлэлцэгддэггүй зөвхөн өмнөх тэгээд цахим хуудсан дээрээ тавьж байгаа.

Уг нь мэргэжлийн байнгын хороо бид, Хууль зүйн байнгын хороо уг нь энэ мэдээллийг хэлэлцээд жил болгон юу нь болж байна, болохгүй байна гэдгийг хэлэлцээд цаашид юун дээр анхаарах вэ гэдгээ ингээд эргэх холбоотой уг нь та бүхэнтэйгээ ажиллах ёстой байдаг. Гэтэл ийм ийм заалттай юм байна. Энэ дээр энэ Улсын Их Хурал дээр энэ хэлэлцүүлэх асуудал дээр тайлангаа зүгээр өгөөд орхидог биш, хэлэлцүүлэх асуудал дээр ямар нэгэн тийм юу гэдэг юм татгалзах зүйл байдаг юм уу гэдгийг танаас бас нэмж асууя. Ингээд 3 асуултдаа хариулт тавья.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

У.Отгонбаяр: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Нэр дэвшигч Максимын Чинбат. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

М.Чинбат: Прокурорын байгууллага дунд хугацааны бодлогын баримт бичиг болох стратеги төлөвлөгөөг 2022 онд анх удаагаа ер нь боловсруулж гаргасан юм. 2023-2026 онд хэрэгжүүлэх энэ стратеги төлөвлөгөөндөө бид хэд нэлээд 4 зорилт тавьсан. Энд иргэдийн итгэл хүндэтгэлийг олж авах, олон нийтэд прокурорын байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, эерэг хандлагыг нэмэгдүүлнэ гээд. 2017 онд ил тод байх энэ зарчим прокурорын үйл ажиллагаанд хуульчлагдсан орж ирсэн. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд бид стратеги зорилт дээрээ ингэж тодорхойлж жил бүр олон нийтийн дунд прокурорын байгууллагад итгэх итгэл ямар байна вэ гэж энэ санал асуулга, санал асуумжийг явуулж байгаа. Энэ гарч байгаа үр дүн хэдийгээр өсөж байгаа ч гэсэн бидний яг хүлээсэн хэмжээний тийм бас түвшинд хүрээгүй байгаа.

2 дугаарт, прокурорын үйл ажиллагааны хараат бус бие даасан байдлыг хангах. Энэ бол манай үйл ажиллагааны үндсэн зарчим. Тэгэхээр тухайн хэргийг хянаж байгаа прокурор өөрийнхөө дотоод итгэлийг үндэслэж, хуульд заасан журмынх нь дагуу шийдвэрлэх энэ зарчмыг бид нар хангуулахын тулд, бид хангуулахын тулд 6 жил ингэж ажиллаж байгаа. Түүнээс тухайн хэрэгт хэн нэгэн гаднаас дээд шатын прокурор юм уу, прокурорын дарга, иргэн аж ахуйн нэгж хэн нэгэн хөндлөнгөөс нөлөөлөх ёсгүй юм байгаа юм. Тийм ч учраас бид прокурорын нөлөөллийн мэдүүлэг гаргах энэ журмыг бас 2022 онд бас анх удаа журамлаж ингэж гаргаж өгч байгаа. Тэгэхээр тухайн прокурор яг өөрөө тэр хавтаст хэрэгт авагдсан нотлох баримт дээр үндэслэж л шийдвэрээ гаргах ёстой. Тэнд хэн нэгэн прокурор нөлөөлөх ёсгүй гэдэг ийм зарчмын байр суурийг барьж, бодлого чиглэлийг барьж ингэж ажиллаж байгаа гэж ойлгож болно.

3 дугаарт энэ Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар жилд 1 удаа Улсын Их Хуралд танилцуулна гээд хуулийн заалт маань байгаа. Энэ хуулийн заалтыг хэрэгжүүлэхийн тулд бид жил бүр прокурорын байгууллага тухайн ондоо хийсэн ажил, цаашид авах ажил, арга хэмжээнийхээ талаарх танилцуулгаа Улсын Их Хуралд хүргүүлдэг. Хэлэлцүүлэхэд асуудал байхгүй тийм. Бид хэлэлцүүлнэ гэвэл ирээд оролцоод асуу.

У.Отгонбаяр: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Баярлалаа. Тэгээд стратеги төлөвлөгөөний дагуу жил бүр санал асуулга явуулж, прокурорын нэр хүнд үйл ажиллагаа ямар байгаа юм гэдгийг иргэдээс бас асуудаг гэж ойлголоо. Тэгээд энэ дээр хамгийн тэгвэл муу үзүүлэлттэй нь юу байна? Би гол нь нөгөө таныг дараагийн 6 жилд тэгвэл юун дээр илүү анхаарах гээд байна гэдгийг л асуумаар байгаа юм л даа. Бодлогын хувьд. Та бол орлогч прокурор буюу бас энэ хууль хэрэгжилтийн энэ асуудал дээр хамгийн гол нөлөөтэй орлогчийнх нь албан тушаалд байгаа.

Тэгээд дотоод журам байдаг юм уу? Зарчмыг бүгдээрээ ойлгож байгаа. Бүх улсад л бүгдээрээ зарчим нь прокурор хараат бусаар ажиллах. Энэ угаасаа зарчим нь тийм. Зарчим тийм боловч бодит байдал дээр тийм биш байна гэдгийг аягүй олон кэйсүүд гараад байгаа шүү дээ. Тэгээд тэрийгээ бид нар нуугаад яах юм бэ? Нуугаад нуугаад бид нар үнэнтэйгээ тулахаас өөр аргагүй. Тийм зарчмаас

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гадуурх ийм асуудлуудаа бид нар хэчнээн журам гаргаад энийг мөрд гээд болохгүй байгаа юм бол өөр ямар өөрчлөлт хийж энийг засах ёстой гэж та бодож байна вэ гэдгийг би таныг бодлогын хэмжээнд юун дээр анхаарах ёстой вэ, анхаарч байгаа хүн бэ гэдгийг л би асуугаад байгаа гэсэн үг. Энэ дээр яг өөрийнхөө байр суурийг.

У.Отгонбаяр: Үндсэндээ ирэх 6 жилд дутуугаа гүйцээх ямар ажил байна л гэж асуугаад байна шүү дээ товчхондоо. 3 дугаар микрофон.

М.Чинбат: Яг хариуцсан чиг үүргийнхээ хүрээнд бид бас цөөнгүй ажил дээр бас анхаарч байгаа. Үүний дотор мөрдөн шалгах ажиллагааны шуурхай байдал, бодит байдлыг тогтоох энэ ажил дээр бас чанарын ахиц гаргах ёстой. Хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх ёстой. Хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх ёстой. Хүний эрх, эрх чөлөөг хангах талаас аль болох зөрчихгүй байх талаас нь хүний эрхийг хангах, хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа бидний бас чухал ажиллагаа гэж бодож байна.

У.Отгонбаяр: Жил болгон санал асуулга явдаг. Тэн дээр аль заалт дээр оноо бага байгаа вэ гэж. Хамгийн бага үзүүлэлт.

М.Чинбат: Ер нь прокурор бол хэрэг шийдвэрлэгдэхгүй удаж байна гэдэг асуудал дээр л бид бас нэлээд анхаарах ёстой гэж бодож байгаа. Санал асуулга дээр. Хэрэг шийдвэрлэгдэхгүй удаж байна гэсэн л асуудал гол байгаа.

У.Отгонбаяр: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Жил болгон явуулдаг прокурорын байгууллагын тэр стратеги төлөвлөгөөний дагуу явуулж байгаа санал асуулга нээлттэй юу иргэдэд? Тэгээд үр дүн нь нээлттэй юү? Тэрийг хаанаас олж авах вэ та хэлээд өгөөч. Би ч гэсэн бас сонирхож үзье. Тэгж байж бас нарийн яахгүй бол асуулт чуулган эд нар дээр харахгүй бол.

У.Отгонбаяр: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

М.Чинбат: Энэ манай олон нийттэй харилцах албанаас зохион байгуулж гэрээт байгууллагаар, хөндлөнгийн байгууллагаар энэ санал асуулгыг авхуулдаг. Жил бүрийн ард 11 дүгээр сард авдаг. Энэ жилийн санал асуулга бол сая явагдаад дууссан байх. Ер нь манай прокурорын байгууллагын цахим сайт дээр тодорхой мэдээллүүд байгаа.

У.Отгонбаяр: Баасанжаргал гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Баасанжаргал: Прокурорын байгууллагын санал асуулгын талаар аягүй сонирхолтой мэдээлэл өглөө. Тэгээд бид нар нөгөө шүүхийн индекс, шүүхийн талаар судалгааг нээлттэй авдаг болохоос яг прокурорынхыг яг ингэж авч байгаагүй учраас бас манай гишүүд тодруулаад байгаа байх. Би Номинчимэг гишүүний асуултыг бүүр нэг зүйлээр тодруулаад асуугаадахъя. Та хуульч хүнийхээ хувьд хариулаарай гэж хүсэх гээд байгаа юм. Хуульчийн байр сууриас. Прокурорын тухай хууль дээр Улсын Ерөнхий прокурор болоод түүний орлогчийг үндэсний аюулгүй байдлын зөвлөмж гарсан тохиолдолд хугацаанаас нь өмнө Ерөнхийлөгч дуусгавар болгох ийм боломжтой заалт 2019 онд орсон. Энэ дээр та

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хуульч хүнийхээ хувьд ямар байр суурьтай байдаг вэ? Энэ зохицуулалт өөрөөр хэлбэл улс төрөөс хараат бус байхад ямарваа нэгэн байдлаар сөргөөр нөлөөлөх ийм хууль зүйн заалт орсон уу? Энэ дээр хуульчид нэлээн маргаантай байдаг учраас би таныг хуульчийнхаа хувьд хариулаарай гэж хүсэж байна. Нэг, эхний асуулт.

2 дахь асуулт. Прокурорын эрүүгийн процессын ажиллагаан дахь прокурорын хяналтад байгаа зарим ажиллагааг шүүхийн хяналтад шилжүүлэх ёстой юу гэдэг дээр шүүхийн хяналтад ямар үе шаттай хэрхэн шилжүүлэх вэ, эсвэл зарим ажиллагаа прокурорын хяналтад байхад хангалттай гэж үзэх үү, үздэг үү гээд энэ дээр таны ер нь байр суурь ямар байдаг вэ? Ямар ямар ажиллагаануудыг шүүхийн хяналтад ер нь явцын дунд шилжүүлэх ёстой гэж үздэг тийм прокурорын хяналт байгаа юу гэсэн ийм 2 дахь асуулт. Энэ бол хүний эрхийн баталгааны маш чухал хууль зүйн баталгаатай холбоотой ийм тогтолцооны шинжтэй асуулт байгаа шүү. Тэгэхээр энэ дээр та яг хуульч хүнийхээ хувьд хариулаад өгөөсэй гэж бодож байна.

3 дугаарт, Хуульчдын холбооны гишүүн хэвээрээ байгаа юу, татвараа төлж байгаа юу гэдэг ийм 3 асуулт асуугаад тодруулъя.

У.Отгонбаяр: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Нэр дэвшигч Максимын Чинбат. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

М.Чинбат: Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлт 19 оны нэмэлт, өөрчлөлтийн талаар асууж байна. Ер нь бол тэр дээр яг дүгнэлт өгөхөд би бас бас татгалзаж байна л даа. Ер нь прокурор бусдаас хараат бусаар л шийдвэр гаргадаг байх ёстой. Тэр улс төр байна уу, эдийн засаг байна уу ямар нэгэн тийм нөлөөлөлгүйгээр бие дааж шийдвэр гаргадаг тийм тогтолцоог л бий болгохын төлөө л зорих ёстой л гэж бодож байна.

2 дугаарт, шүүхийн хяналтад зарим ажиллагаа ялангуяа энэ хүний эрх, эрх чөлөөтэй, хүний эрхийг хөндсөн ийм ажиллагаануудыг бид бас ингээд үе шаттай ингээд шилжүүлж байна л даа. Хуучин бол цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ баривчлах чинь прокурор, мөрдөгч шийддэг байсан. Энэ эрх зүйн тогтолцооныхоо мөн чанараас ч бас уламжилж ингэж улбаалж ингэж явж байгаа. Хүний эрхтэй холбоотой асуудлуудыг зарим мөрдөн шалгах ажиллагаа зөвшөөрлийн асуудлуудыг шүүхэд шилжүүлдэг. Тэгэхээр яг нэмж ямар ажиллагаа явуулах юм байгаа юм. Эцэст нь нөгөө шүүх маань өөрөө энэ зөвшөөрөл олгосон хэрэг, маргааныг эцэслэн хөндлөнгийн нөлөөлөлгүйгээр шийддэг байгууллага учир энэ дээр бас аль аль талд нь болгоомжтой хандах ёстой л гэж би миний хувийн байр суурь гэж илэрхийлэхээр байна.

3 дугаарт нь Монголын Хуульчдын холбооны гишүүн, прокуроруудыг энэ юунд гишүүнчлэлээр элсээд ингээд үйл ажиллагаанд оролцоод явж байгаа гишүүн.

У.Отгонбаяр: Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Яах вэ би тэр шүүхийн хяналтад шилжүүлэхийг бүүр тодорхой хариулаад өгөөч гэж хүсэж байна. Одоо ямар прокурорын хяналтад байгаа ямар ямар ажиллагаануудыг ер нь явцын дунд шүүхийн хяналтад

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шилжүүлэх ёстой гэдэг тийм байр суурь дээр нэлээн тодорхой хариулаад өгөөч гэж хүсэж байна.

2 дугаарт нэмээд асуухад Хүүхэд, гэр бүлийн шүүхийн байгуулагдах гээд процессын хууль нь яг ид хэлэлцэгдэж байгаа. Энэ дээр яг прокурорын байгууллагын оролцоог та нар ер нь хэр харж байгаа вэ? Ямар аль хэсэг дээр нь прокурорын хяналт ер нь аль процесс дээр нь илүү чухал гэж харж байгаа вэ гэдэг дээр нэг прокурорын байгууллагын байр суурийг 2 дахь асуулт дээрээ тодруулъя.

У.Отгонбаяр: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

М.Чинбат: Прокурорын хяналтаас аль хэсгийг нь шүүхэд шилжүүлэх вэ л гээд тогтолцооны юм асуугаад байна л даа. Тэгэхээр энд тодорхой асуудал гарвал бид байр сууриа илэрхийлье. Тэрнээс яг одоо өнөөдөр энэ ажиллагаагаа тэгж шилжүүлье, тэрийгээ ингэх гэх одоо яг шууд хариулах ийм боломж байхгүй байна.

2 дугаарт, Хүүхэд, гэр бүлийн шүүх 26 оны 1 сарын 1-нээс хэрэгжихээр хуулийн зохицуулалт явж байгаа. Энэ дээр ер нь хүүхэд хохирсон, холбогдсон эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор ялангуяа дагнаж прокурор, дагнасан прокурорууд энд хяналт тавьж ажиллаж байгаа. Дагнасан шүүх байгуулагдаад ирэх юм бол энэ хэргийн шийдвэрлэлт, гарах шийдвэр бас тодорхой болоод ирвэл прокурор бас энэ дээр бас дагнаж явж байгаа учраас улам мэргэшиж энэ хэргийг шийдвэрлэдэг хуульд.../минут дуусав./

У.Отгонбаяр: Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Ганбат: Ерөнхийдөө прокурорын байгууллага боломжийн байгаа. Ерөнхий прокурорыг 6 жилээр ингээд сунгачихсан байгаа. Тэгээд орлогч прокуроруудыг бас сунгах гээд ингээд Ерөнхий прокурор нь саналаа гаргасан юм байна. Дэмжиж байна ер нь бол. Ингээд ирэх 6 жилд та бүхний хийх ажил их байх байх аа гэж ойлгож байна. Яагаад гэвэл ажилтай, туршлагатай, ажлаа хийгээд сурчихсан улсууд энэ ажлаа хийнэ.

Гэхдээ хууль хяналтын байгууллага одоо сайн байгаа юу гэвэл бас үгүй. Шаардлагын хэмжээнд байна уу гэвэл үгүй гэж хэлнэ. Тэр нь юугаар илэрч байна вэ гэхээр энэ авлига, албан тушаалын хэргүүд байна. Энэ хараат бус байгууллагын өгдөг оноогоор бид нар чинь нөгөө л газраа л байгаад байна шүү дээ. Тэгээд энд хамгийн чухал юм бол улс төрийн эр зориг. Ялангуяа нэг нам эрх бариад их олон жил явлаа. Одоо төр засаг нь ч бас ингээд нэг талдаа гараад хэвийн ажиллах гээд ингээд явж байх шиг байна. Прокурорын байгууллага бол авлига, албан тушаалын хэрэгтэй бол тэмцэх тэмцэж байгаа, өшөө ч сайн тэмцэнэ гэдэг дээр хэлэлцэхгүй байна.

Цаашдаа энэ дээр энэ хөрөнгө хураах асуудал байдаг. Энэ асуудал маань яг хуулийнхаа боломж, бололцоогоор ингэж хураагдаж байгаа юу? Хууль бусаар хэн ч хөрөнгөжих ёсгүй л дээ. Энэ байдал ямар байгаа вэ? Нөгөө талаар иргэдийн хувьд хууль биелэгдээд ингээд байгаад байдаг, улс төрчдийн хувьд ялангуяа эрх барьж байгаа энэ намын нөхдүүдийн хувьд хууль, хяналтын байгууллага ажлаа хийхгүй байна гээд манай сонгогчид хэлж байгаа шүү. Энэ дээр нэг хүлээлтийн байдалтай байна.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тухайлбал, өнгөрсөн жилүүдэд прокурорын зөвшөөрөлтэйгөөр нүүрсний хулгайчдыг зарлаж байсан АТГ. Дараа нь хэд хэдэн нэлээн хэдэн Их Хурлын гишүүд нүүрсний хулгайчдыг зарлуулчихаад тэгээд дараа нь тодорхой хугацааны дараа ямар нэгэн холбогдолгүй болоод л гарч байсан. Танай прокурорын байгууллагаас Ерөнхий прокурор нь бас хэлж л байсан л даа. Энэ Их Хурлын танхимаас эхлэх ёстой, энэ танхимаас эхлэх ёстой, энэ асуудлыг шийдэж байж бусдад үлгэр дуурайлал болно гээд ярьж байсан. Би тэрэнтэй санал нэг байгаа. Энэ талаар та ямар бодолтой байна? Прокурорын байгууллага ямар бодолтой байна гэсэн ийм асуултууд байна л даа. Энэ дээр иргэд сэтгэл хангалуун биш байгаа. Хүлээлтийн байдал.../минут дуусав./

У.Отгонбаяр: Ганбат гишүүн бас үг хэллээ гэж ойлголоо зөв үү? Ганбат гишүүний асуултад хариулъя. Нэр дэвшигч Максимын Чинбат. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

М.Чинбат: Ганбат гишүүний асуултад хариулъя. Ер нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор эд хөрөнгө хамгаалах, хураах, битүүмжлэх энэ ажиллагаа бас прокурор хяналт дор явагдаж байгаа. Сүүлийн 6 жилийн байдлаар гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааны тоо баримт миний танилцуулгад дурдсан байгаа. Түүнээс гадна гадаад улсад гарсан хөрөнгийг царцаах, буцаан авчрах энэ ажиллагаа бас олон улсын энэ эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх энэ шугамаар бас явагдаж байгаа. 2019-2025 оны хооронд мөрдөн шалгах байгууллагууд гадаад улсад гарсан 13 сая долларын хөрөнгийг олж тухайн шатанд нь битүүмжилж Монгол улсад эргүүлэн авчрах ийм ажиллагаа явуулсан. Энэ дээр прокурорын байгууллага эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх энэ улс орнууд адил, тэгш байх энэ зарчимд нийцүүлж олон улсын байгууллага гадаад улс орнуудтай ажиллагаа явуулсны үр дүнд энэ ажиллагаа зохих түвшинд зохих үр дүнг авчирсан гэж ойлгож байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Мөнгө угаах терроризм санхүүжүүлэхтэй тэмцэх энэ хөтөлбөр хэрэгжүүлэх энэ хүрээнд энэ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Улсын Ерөнхий прокурорт тусгай алба бид байгуулж, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, чиглэлээр зангидах Үндэсний хөтөлбөр, олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг хангуулах энэ бодлого, зорилтыг тодорхойлохын төлөө ийм алба байгуулж ажиллаж, энэ алба нь нэгж прокурорын газрууддаа тодорхой мэргэжил арга зүйгээр хангаж ингэж ажилласны үр дүнд энэ авлигатай тэмцэх ажил бас нэлээн сайн үр дүнг бий болгох байх гэж ингэж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан байгаа.

У.Отгонбаяр: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Улсын Их Хурлаас энэ хяналтын түр хороо гэж байгуулаад сонсгол хийгээд ингээд явж байгаа. Хэд хэдэн түр хороо хуралдаад нүүрсний, Оюу толгой, удахгүй Харбины гэрээгээр ингээд болно. Энэ түр хорооны дараа ямар үйл ажиллагаа хууль хяналтын байгууллага тухайлбал прокурорын байгууллагууд явуулдаг вэ? Ямар нэгэн үр дүн гаргаж байна уу, та бүхний ажилд нэмэр болж байгаа юу гэсэн ийм асуулт байна.

Д.Ганбат: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

М.Чинбат: Улсын Их Хурлаас байгуулагдсан хяналтын сонсголтой холбоотой тийм хяналтын түр хорооны ажлын хэсгүүд байгуулагддаг. Тэр ажлын хэсгүүдээс хэлэлцээд Улсын Ерөнхий прокурор, мөрдөх байгууллагуудад сонсголын үр дүнгээр тодорхой тооны чиглэл, бодлого, баримт бичгийг хүргүүлж байгаа. Тэрийг нь бид хүлээж авч, мөрдөн шалгах байгууллагуудад зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авхуулахаар бас харьяаллын дагуу шилжүүлдэг. Тэгээд энэ сонсголыг тухайлбал нүүрсний гэх сонсголын үр дүнд бидэнд ирүүлсэн бүхий л бичиг баримтуудыг бид авч харьяалах байгууллагууд нь гаргаж, мөрдөн шалгах байгууллагууд дээр хэргийн, гэмт хэргийн шинжтэй үйлдэл болгон дээр нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, зохих шалгалтын ажиллагааг ингэж явуулж ирсэн.

У.Отгонбаяр: Байнгын хорооны гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Улсын Ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд Максимын Чинбатыг томилохоор Монгол Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 12 гишүүн дэмжиж, 80 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг танилцуулна. Уучлаарай Сайнзориг.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа. Ажлын хэсгийнхэн, нэр дэвшигчид баярлалаа.

15.03 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР